Хавсралт 1

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугээр сарын 26-ны өдөр | Улаанбаатар хот

| Д/д | Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан үйл ажиллагаа | Зорилт, үйл ажиллагаа | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Хийгдсэн ажлууд | Өмнөх долоо хоногийн хэрэгжилтийн хувь | Энэ долоо хоногийн хэрэгжилтийн хувь | Хүлээгдэж буй ажлууд | Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 4.2.2. | Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх | Налайх барилгын материалын үйлдвэр технологийн парк байгуулна. | 2022 | 2024 | • НБМҮТП-ийн үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч “Вилл вест” ХХК нь “110/10кВ-ын станцын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл”-ийн тоног төхөөрөмжийн суурь, “10кВ-ын кабель шугамын угсралт”-ын ажлыг бүрэн дуусгасан. Цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтад 2023 онд нийслэлийн төсвөөс 500,000,000 төгрөг тусгагдсан бөгөөд төсвийн тодотголоор 7,000,000,000 төгрөг тусгагдсан. Мөн үлдэгдэл санхүүжилт болох 6,208,000,000 төгрөгийг Нийслэлийн 2024 оны төсөвт батлуулсан.<br>• Паркийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ, БХБЯ болон холбогдох газруудад хүсэлт гаргаад байна.<br>• 2023 оны барилгын материалын үнийн индексийн өсөлтөөс хамаараад цэвэрлэх байгууламжийн төсвийн магадлал “ББСМО” ХХК-р төсвийг шинэчилж батлуулсан.<br>• НБМҮТП-г түшиглэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах Тогтоол, захирамжийн хүрээнд 60 га талбайд Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хөрөнгө оруулалтын санал болон зураг төсөл гүйцэтгүүлэх саналыг НЗДТГ-т хүргүүлсэн.<br>• Паркийн дэд бүтцийн барилга байгууламжуудын төсөл арга хэмжээг (Дулааны станц, Цэвэрлэх байгууламж, Ус дулаан дамжуулах 9 төв, Цэвэр усан хангамж болон инженерийн шугам сүлжээний барилга байгууламж г.м) хэрэгжүүлэхэд улс, нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын саналаа хүргүүлээд байна.<br>• 2023 онд 5–н үйлдвэрийн бүтээн байгуулалт хийгдэх ба 12-р сарын байдлаар “Сайхан улаан оргил” ХХК “Төгс бридж”ХХК, “Эко минерал”ХХК, “Электрокем Монголиа” ХХК, “Нюу метод” ХХК аж ахуй нэгж үйлдвэрийн барилгын бүтээн байгуулалт ажлаа хийж байна. | 0% | 30% | Паркийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн зураг төслүүдийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. | Паркийн дэд бүтцийн санхүүжилт шаардлагатай байна.<br>Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулах. | НЗДТГ |

**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ**